



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 772

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Отгонсүхтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 6.6.1, 8.2.в. дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:


1.1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Б.Отгонсүхийг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

1.2. Б.Отгонсүхэд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгохыг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс (П.Амарцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ